Их гэрэл асаалттай үед их гэрэл угаагч нэг удаа ажиллана. Үргэлжлүүлэн их гэрэл угаагч хөшүүргийг таван удаа татах тутамд нэг удаа ажиллана.

# Хойд шил арчигч ба угаагч




**1** ○ Off

**2** - - - Тасалдсан горим

**3** ── Хэвийн




**4** Шил арчигч/угаагч давхар ажиллах

Хөшүүргийг түлхэх үед шил арчигч болон угаагч ажиллана.

Камер угаагчтай автомашин: Multi-terrain дэлгэцийн камерыг камер угаагч автоматаар угаана.

# Жолоодлогын горим сонгох товч

Жолоодлогын нөхцөлд тохируулан жолоодлогын горим сонгох боломжтой.

## Системийн эд анги




A Мэдээллийн дэлгэц (→P. 40)

B MODE SELECT товч

C DRIVE MODE товч

## Жолоодлогын горим сонгох




1 DRIVE MODE товч дарна. Товч дээрх A индикатор асна.




2 MODE SELECT товчийг баруун болон зүүн эргүүлж мэдээллийн дэлгэц дээр горим сонгоно.

• Хэвийн горим
Шатахуун бага зарцуулалт, дуу чимээ бага, динамик гүйцэтгэлийг тэнцвэртэйгээр бүрдүүлэх горим. Хотын жолоодлогод тохиромжтой.

• Комфорт горим
Автомашины амортизаторын системийг удирдах замаар илүү тав тухтай зорчих боломж бүрдүүлнэ. Хотын нөхцөлд тохиромжтой. Горим идэвхжих үед комфорт горимын индикатор асна.

• Эко жолоодлогын горим
Хөдөлгүүрийн хаазыг удирдах, агааржуулалтын системийн ажиллагааг удирдах (халуун/хүйтэн) замаар шатахуун зарцуулалтыг сайжруулах, байгаль орчинд ээлтэй байдлаар хөдөлгөөн эхлэхэд жолоочид туслана. Горим идэвхжих үед эко горимын индикатор асна.

• SPORT S горим
Хурдны хайрцаг удирдах замаар хурд авалтыг нэмэгдүүлнэ. Тус горим нь хүчтэй хурд авалт шаардлагатай үед тохиромжтой. Горим идэвхжих үед SPORT S горимын индикатор асна.

• SPORT S+ горим
Хурдны хайрцаг, хөдөлгүүр, амортизаторын ажиллагаа, жолооны механизмыг цогцоор удирдах замаар автомашины жолоодлого болон тогтвортой байдлыг бүрдүүлж спорт жолоодлого хийхэд тохиромжтой болгодог. Горим идэвхжих үед SPORT S+ горимын индикатор асна.

• Custom горим
Явах эд анги, кузов, агааржуулалтын системийн функцийн ажиллагааг таны хүссэн тохиргоонд тохируулна. Тус горимыг зөвхөн мултимедиа дэлгэцийн жолоодлогын горим тохируулах дэлгэцээр идэвхжүүлнэ. CUSTOM горимын индикатор асна.

# Кузов өргөгч

Жолоодлогын нөхцөл байдалд нийцүүлэн автомашины өндрийг тохируулна.

## Системийн эд анги

### Өндөр сонгох товч




A Өндөр

B Нам

### Хянах самбар




A AHC дэлгэц

B Хялбар бууж суух горимын индикатор

### Урд олон үйлдэлт удирдлагын самбар




A Автомашины өндрийн горим

B AHC дэлгэц

C Хялбар бууж суух горимын товч

D Өндрийн удирдлага унтраах товч

## Хялбараар бууж суух горим

Тус горимыг автомашинд хялбараар бууж суух, мөн эд зүйл ачихад ашиглах боломжтой.

Горимыг асаах үед дөрвөн дугуйн хөтлөх системийн товчийг H4-д шилжүүлээд урд олон үйлдэлт удирдлагын самбар дээрх хялбараар бууж суух горимын товчийг дарна.

Горим идэвхжих үед товч дээрх A индикатор болон хянах самбарын хялбараар бууж суух горимын индикатор асна.




Хялбараар бууж суух горим идэвхтэй үед автомашин зогссоны дараа 30 секундын дотор асаах товч унтраасан нөхцөлд автомашины өндөр автоматаар намсана.

Өндөр намсаж эхлэх үед дуут дохио 2 удаа дуугарна. Өндөр намсаж буйг илтгэж намсах явцад хялбараар бууж суух горимын индикатор асна.

Үйлдэл дуусах үед тус горимын индикатор унтарна.

# Дөрвөн дугуйн хөтлөх систем

Дөрвөн дугуйн хөтлөх системийн удирдлагын товч болон төвийн дифференциал цоожлогчийн товч ашиглан дараах горимуудыг сонгох боломжтой.

## Дөрвөн дугуйн хөтлөх системийн удирдлагын товч




A H4 (өндөр хурдны байрлал)

Бүх төрлийн зам дээр хэвийн жолоодлого хийх үед ашиглана.

B L4 (нам хурдны байрлал)

Огцом өгсүүр, уруу, бартаат, элс, шавартай замаар зүтгүүлэх зэрэг автомашины зүтгэх хүчийг дээд зэргээр шаардсан үед ашиглана.

Нам хурдны индикатор асна.

## Төвийн дифференциал цоожлогчийн товч



Автомашин суусан, эсвэл хальтиргаатай, энхэл донхолтой замаар явах үед төвийн дифференциалыг цоожлоно.

Төвийн дифференциал цоожлогчийн индикатор асна.

Төвийн дифференциалыг салгах үед товчийг дахин дарна.

Автомашин тухайн суусан газраас гарсан, эсвэл хальтиргаагүй, тэгш зам дээр гарсны дараа төвийн дифференциалыг салгана.

# Crawl Control (эргэлтэд туслах функцтай)

Хааз болон тоормос ашиглалгүйгээр тогтмол бага хурдаар хэт бартаатай замаар явах боломж бүрдүүлсэн систем юм. Зүтгэх хүчний алдагдал болон хальтиргаатай зам дээрх халтиргааг боломжит бага хэмжээнд бууруулж автомашины тэнцвэр алдахаас сэргийлдэг.

## Системийн эд анги




A Хянах самбар (→P. 40)

B Урд олон үйлдэлт самбар

C MODE SELECT товч

D DAC/CRAWL товч

## Сонгох боломжтой горим

Замын нөхцөл байдалд нийцүүлэн дараах 5 горимоос сонгох боломжтой.




1 Lo

Хадархаг, уруу замд тохиромжтой.

2 Lo-Mid

Хадархаг, уруу, эсвэл овгор тов-гортой налуу замд тохиромжтой.

3 Mid

Овгор товгортой налуу зам дээр тохиромжтой.

4 Mid-Hi

Цас, шавар, хайрга чулуутай, элс, шороо, овгор товгор (өгсүүр) өвстэй зам дээр тохиромжтой.

5 Hi

Цас, шавар, хайрга чулуутай, элс, шороо, овгор товгор (өгсүүр) өвстэй зам дээр тохиромжтой.

## Эргэлтэд туслах функц

Энэ функц нь нарийн эргэлтээр эргэх үед жолооны хүрдний ажиллагааг дэмждэг. Функц нь жолоодлогын үед тогтмол хурдыг барих ба жолооны хүрдийг эсрэг чиглэлд эргүүлэх шаардлагатай эргэлт дээр жолооны хүрдний эргэлтийн тоог бууруулдаг.

1 Crawl Control асаалттай үед урд олон үйлдэлт удирдлагын самбарын товч дарж бартаат замын жолоодлогын мэдээллийн дэлгэц гаргана.




2 Эргэлтэд туслах товч дарна.

Эргэлтэд туслах функцийн A болон мэдээллийн дэлгэцний индикатор асна.

Системийг унтраах үед товчийг дахин дарна.

# Multi-terrain Select

Тус систем нь бартаатай замын жолоодлогыг сайжруулах систем юм.

Тухайн замын нөхцөлд тохирох горимыг сонгоно.

Тоормосны удирдлага, зүтгэх хүчний удирдлага, амортизаторын удирдлагыг тухайн сонгосон горимд нийцүүлэн удирдана.

AUTO горим сонгогдсон үед замын нөхцөлд нийцүүлэн тоормосны удирдлага, зүтгэх хүчний удирдлага, амортизаторын удирдлагыг автоматаар тохируулна.

## Системийн эд анги




A MTS товч

B MODE SELECT товч

C Мэдээллийн дэлгэц

Сонгосон горимыг харуулна.

## Горим солих




1 MTS товч дарна.

Товч дарах үед товчны A индикатор асна.



2 MODE SELECT товчийг баруун зүүн эргүүлэн мэдээллийн дэлгэц дээр жолоодлогын горим сонгоно.

Дөрвөн дугуйн хөтлөх системийн товчны байрлалаас хамаарч дараах горимуудаас сонгох боломжтой.

▶ Дөрвөн дугуйн хөтлөх системийн товч L4-д байгаа үед

| Горим | | Замын нөхцөл |
|---|---|---|
|  | AUTO | Бүх замд тохиромжтой |
|  | SAND | Элсэрхэг замд тохиромжтой |
|  | MUD | Шавартай замд тохиромжтой |
|  | ROCK | Хадархаг замд тохиромжтой |

Тоормосны удирдлага идэвхжсэн үед шарвалтын индикатор асна.

▶ Дөрвөн дугуйн хөтлөх системийн товч H4-д байгаа үед

| Горим | | Замын нөхцөл |
|---|---|---|
|  | AUTO | Бүх замд тохиромжтой |
|  | DIRT | Шороон замд тохиромжтой |
|  | SAND | Элсэрхэг замд тохиромжтой |
|  | MUD | Шавартай замд тохиромжтой |
|  | DEEP SNOW | Гүнзгий цастай замд тохиромжтой |

Тоормосны удирдлага идэвхжсэн үед шарвалтын индикатор асна.

SAND, MUD эсвэл DEEP SNOW горим сонгогдсон үед VSC автоматаар цуцлагдана. (VSC OFF индикатор асна.)

# Multi-terrain дэлгэц

Multi-terrain дэлгэц нь жолоочид автомашины ойр орчмыг нягтлах, харах боломж олгодог. Бартаат замаар явах үед замын байдлыг нягтлах, зогсоолд байрлуулах үед аливаа саадыг харах зэргээр янз бүрийн нөхцөл байдалд жолоочид шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг систем юм.



VIEW товчийн байрлалыг зурагт үзүүлэв.

# Ухаалаг утас, холбооны хэрэгсэл холбох

Bluetooth®, эсвэл Wi-Fi® ашиглах

## Мултимедиа систем ашиглан Bluetooth® төхөөрөмж бүртгэх

Гарны оролцоогүй дуудлага хийх, эсвэл Bluetooth® хөгжим ашиглахын өмнө гар утас, эсвэл зөөврийн төхөөрөмжийг бүртгэнэ. Бүртгэл дууссан үед Bluetooth® автоматаар мултимедиа систем асаах бүрт холбогдоно.

Apple CarPlay/Android Auto төхөөрөмж USB-р холбогдсон үед төхөөрөмж автоматаар бүртгэгдэнэ.

Bluetooth® төхөөрөмж холбогдоогүй үед жолооны хүрдний [ ] товчийг удаан дарж бүртгэлийн дэлгэц гаргах боломжтой.

1 Үндсэн менюнээс [ ] -г дарна.

2 [Bluetooth & Devices]-г дарна.

3 [Manage devices]-г дарна.

4 [Add another device]-г дарна.

- Төхөөрөмж бүртгүүлээгүй үед **5**-р үйлдэлд шилжинэ үү.
- Төхөөрөмж мултимедиа системд холбогдох үед төхөөрөмжийг салгах үйлдлийг баталгаажуулах дэлгэц гарч ирж болно. Төхөөрөмжийг бүртгэх үед төхөөрөмжийг салгана.




5 [If not found]-г дарна.

6 Үндсэн хэсгээс төхөөрөмжийг сонгож бүртгэнэ.

- Төхөөрөмжийн нэрний оронд Bluetooth® хаяг дэлгэцээр гарч болно.
- Үндсэн хэсэг дээр төхөөрөмж бүртгэх бүртгэл гарахгүй үед Bluetooth® төхөөрөмжөөс бүртгэх оролдлого хийнэ.
- Bluetooth® төхөөрөмжийн зарим загварууд Bluetooth® төхөөрөмжийн дэлгэц дээрээ сонгоогүй үед төхөөрөмжийн жагсаалт дотор гарч ирэхгүй байж болно. Дэлгэрэнгүйг Bluetooth® төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.

7 Дэлгэц дээрх PIN код Bluetooth® төхөөрөмжийн PIN кодтой таарч байгааг нягтлаад [OK]-г дарна.

- Бүртгэлийг дуусгахын тулд зарим Bluetooth® төхөөрөмжийг ажиллуулах шаардлагатай байдаг.
- Зарим тохиолдолд бүртгэл хийх зааварчилгаа дэлгэцээр гарч болно. Зааварчилгааны дагуу бүртгэл хийнэ.
- Төхөөрөмжийн үндсэн тохиргоог дэлгэцээр харуулж болно. Зааварчилгааны дагуу үйлдэл хийнэ.
- Apple CarPlay-н тохиргоо дэлгэцээр гарч болно. Зөвшөөрсөн тохиргоо хийсэн үед Apple CarPlay-н дэлгэц дэлгэцээр гарна.
- Холболт амжилттай хийгдсэнийг илтгэх мэдээлэл дэлгэцээр гарах ба бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж дэд меню дотор гарна.
- Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх мэдээлэл гарсан үед дэлгэцийн зааварчилгааны дагуу үйлдэл хийнэ.

## ■Бүртгэлийг Bluetooth® төхөөрөмжөөс хийх

Мултимедиа систем дээр хайлт хийсэн ч Bluetooth® төхөөрөмж илрэхгүй үед дараах дарааллын дагуу Bluetooth® төхөөрөмжөөс бүртгэл хийнэ.

1 Үндсэн менюнээс [ ]-г дарна.

2 [Bluetooth & Devices]-г дарна.

3 [Manage devices]-г дарна.

4 [Add another device]-г дарна.

- Төхөөрөмж бүртгэгдээгүй үед **5**-р үйлдэл рүү шилжинэ
- Төхөөрөмж мултимедиа системд холбогдох үед төхөөрөмжийг салгах үйлдлийг баталгаажуулах дэлгэц гарч ирж болно. Төхөөрөмжийг бүртгэх үед төхөөрөмжийг салгана.




5 Bluetooth® төхөөрөмж дээр ашиглах мултимедиа системийг бүртгэнэ.

- Bluetooth® төхөөрөмжийн үйлдлийн дарааллын дагуу үйлдэл хийнэ.
- Бүртгэл хийх үйлдлийг эхлэхээс өмнө тус Bluetooth® холболтын дэлгэцийг гаргана.

6 Дэлгэц дээрх PIN код Bluetooth® төхөөрөмжийн PIN кодтой таарч байгааг нягтлаад [OK]-г дарна.

- Бүртгэлийг дуусгахын тулд зарим Bluetooth® төхөөрөмжийг ажиллуулах шаардлагатай байдаг.
- Зарим тохиолдолд бүртгэл хийх зааварчилгаа дэлгэцээр гарч болно. Зааварчилгааны дагуу бүртгэл хийнэ.
- Төхөөрөмжийн үндсэн тохиргоог дэлгэцээр харуулж болно. Зааварчилгааны дагуу үйлдэл хийнэ.
- Apple CarPlay-н тохиргоо дэлгэцээр гарч болно. Зөвшөөрсөн тохиргоо хийсэн үед Apple CarPlay-н дэлгэц дэлгэцээр гарна.
- Холболт амжилттай хийгдсэнийг илтгэх мэдээлэл дэлгэцээр гарах ба бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж дэд меню дотор гарна.
- Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх мэдээлэл гарсан үед дэлгэцийн зааварчилгааны дагуу үйлдэл хийнэ.

## ■Жолооны хүрдний товч ашиглан удирдах

Жолооны хүрдний товч ашиглан дуудлага авах, дуудлага хийх зэрэг зарим гарны оролцоогүй дуудлагын функц ашиглах боломжтой. Мултимедиа системийн ажиллагааны статусаас хамаарч жолооны хүрдний товчны функц өөрчлөгдөнө.



- Товч дарж үйлдэл хийнэ.

[+] товч

Хонхны аяны дууны түвшин, эсвэл хүлээн авагчийн дууны түвшинг нэмнэ.

Үргэлжлүүлэн тохируулах үед удаан дарна.

[-] товч

Хонхны аяны дууны түвшин, эсвэл хүлээн авагчийн дууны түвшинг хасна.

Үргэлжлүүлэн тохируулах үед удаан дарна.

[] товч

Дуу хоолойн командаар дуудлага хийх боломжтой.

Дуудлага хийх товч удаан дарж дуу хоолойн командыг дуусгана.

[] товч

- Дуудлага амжилтгүй болсон үед дуудлагын түүхийг харуулна.
- Дуудлага хийнэ.
- Дуудлага хийх, утсаар ярих үед дуудлагыг дуусгана.
- Дуудлага ирэх, дуудлага хүлээгдэх үед дуудлагыг авна.

## Дуудлагын түүхээс дуудлага хийх

Ирсэн, залгасан дуудлагын түүхэд бүртгэгдсэн утасны дугаар ашиглан дуудлага хийх боломжтой.

1 Үндсэн менюнээс [ ]-г дарна.

2 [Recents]-г дарна.




3 Холбоо барих хаягийг сонгоно.

Холбоо барих хаягт бүртгэгдээгүй утасны дугаарны зөвхөн дугаар дэлгэцээр гарна.

4 Дуудлага хийх утасны дугаарыг сонгоно.

## Байнга холбогддог дугаарын жагсаалтаас дуудлага хийх

Байнга холбогддог дугаарын жагсаалтад дугаар бүртгэж дуудлага хийх боломжтой.

1 Үндсэн менюнээс [ ]-г сонгоно.

2 [Favourites]-дарна.




3 Байнга холбогддог дугаарын жагсаалтаас дуудлага хийх хүний дугаарыг сонгоно.

4 Дуудлага хийх утасны дугаарыг сонгоно.

## Холбоо барих хаягнаас дуудлага хийх

Мултимедиа системд бүртгэсэн холбоо барих хаягнаас дуудлага хийх боломжтой.

1 Үндсэн менюнээс [ ]-г дарна.

2 [Contacts]-г дарна.

3 Холбоо барих хаягийг сонгоно.




4 Дуудлага хийх утасны дугаарыг сонгоно.

## Дуудлага хүлээн авах

Дуудлага хүлээн авах үед дуудлагын хонх дуугарах ба ирж буй дуудлагын дэлгэц, эсвэл анхааруулга дэлгэцээр гарна. Дуу хоолойн командны [Voice support] идэвхитэй үед дуу хоолойн команд ажиллаж эхэлнэ.




● Дараах үйлдлээр хүлээн авна.

- [ ]-г дарна.
- Жолооны хүрдний [ ] товч дарна.
- Дуу хоолойн командын системд дуу хоолойн команд өгнө.

## Мессежний функцаас дуудлага хийх

Мессежний функцаас гарны оролцоогүй дуудлага хийх боломжтой.

Тус функц зарим улс орон, бүс нутагт ашиглагдах боломжгүй.

● Цэнхэр дугаар дээр дарж дуудлага хийнэ.
Дараалсан тоонуудыг систем утасны дугаар гэж таниж болно. Мөн гадаад утасны дугаар зэрэг зарим утасны дугаар танигдахгүй байж болно.

### ■И-мэйл, SMS, эсвэл MMS мессежний дэлгэцээс дуудлага хийх

И-мэйл, SMS, эсвэл MMS мессеж илгээгч рүү дуудлага хийх боломжтой. И-мэйлний хувьд утасны дугаар тус холбоо барих хаяг дээр бүртгэгдсэн байх ёстой.

И-мэйл/MMS функц зарим улс орон, бүс нутагт ашиглагдах боломжгүй.

1 Үндсэн менюнээс [ ]-г дарна.

2 [Messages]-г дарна.

3 Хаяг сонгоно.

4 Мессеж илгээгчийг сонгоно.




5 Жолооны хүрдний [ ], эсвэл [ ] товч дарна.

Холбоо барих бүртгэлээс хамаарч утасны дугаар сонгох шаардлагатай.

# Агааржуулалтын автомат горим

Суудал халаагч, суудлын агааржуулагч ба жолооны хүрд халаагч (эдгээр нь тоноглогдсон автомашинд) нь агааржуулалтын системийн хэмийн тохиргоо, гадна болон салоны агаарын хэмтэй уялдан автоматаар удирдагдана. Тус функц нь систем тус бүрийг тохируулах шаардлагагүйгээр тав тухыг хангана.

## Агааржуулалтын автомат горим асаах

▶ Зүүн жолооны хүрдтэй




"CLIMATE CONCIERGE" товч дарна.

Товчин дээрх индикатор асч автомат агааржуулалтын систем, суудал халаагч, суудлын агааржуулагч, жолооны хүрд халаагч автомат горимоор ажиллана.

Аль нэг системийг гар аргаар удирдсан үед индикатор унтарна. Нөгөөтэйгүүр бусад бүх систем автоматаар ажиллана.

▶ Баруун жолооны хүрдтэй



# Урд автомат агааржуулалтын систем

Температурын тохиргооноос хамаарч агааржуулагчийн байрлал, сэнсний хурд автоматаар тохируулагдана.

Агааржуулалтын системийг агааржуулалтын удирдлагын самбар болон урд олон үйлдэлт удирдлагын самбарын дэлгэцээр удирдах боломжтой.

## Удирдлагын самбар

▶ Агааржуулалтын удирдлагын самбар (зүүн жолооны хүрдтэй)




A Зүүн талын температур удирдлагын товч

B Автомат горимын товч

C “OFF” товч

D Гадна агаар/дотор агаарын горимд солих товч

E Баруун талын температур удирдлагын товч

F “A/C” товч

G Хойд цонх болон хажуугийн толины цан арилгагч

H Салхины шилний цан арилгагчийн товч

▶ Агааржуулалтын удирдлагын самбар (баруун жолооны хүрдтэй)




A Зүүн талын температур удирдлагын товч

B Гадна агаар/дотор агаарын горимд солих товч

C “OFF” товч

D Автомат горимын товч

E Баруун талын температур удирдлагын товч

F Хойд цонх болон хажуугийн толины цан арилгагч

G Салхины шилний цан арилгагчийн товч

H “A/C” товч

▶ Урд олон үйлдэлт самбар




**A** Зүүн талын үлээх чиглэл тохируулах товч

**B** Сэнсний хурдны удирдлагын товч

**C** Баруун талын үлээх чиглэл тохируулах товч

**D** “OPTION” товч

**E** “REAR” товч (→P. 75)

**F** “FRONT” товч

**G** “SYNC” товч

**H** “A/C” товч

### Сонголтын удирдлагын дэлгэц

“OPTION” товч дарж сонголтын удирдлагын дэлгэц гаргана.

Функцийг (ON) болон (OFF) тохиргоонд өөрчилж болно.




A Эко агааржуулалтын горим

B nanoe™ X* (тоноглогдсон автомашинд)

C Урд суудалд төвлөрсөн агаарын урсгалын горим (S-FLOW)

*: nanoe™ ба nanoe™ тэмдэг нь Панасоник Корпорацийн худалдааны тэмдэг болно.

## Автомат горим ашиглах

1 Агааржуулалтын удирдлагын самбарын автомат горимын товч дарна.

2 Гадна дотор агаарын горимыг автомат горимд тохируулна. (тоноглогдсон автомашинд)

3 Температур тохируулна.

4 Зогсоох үед “OFF” товч дарна.

# Арын агааржуулалтын систем

Тухайн тохируулсан температурын тохиргоонд нийцүүлэн үлээх агааржуулалтын байрлал болон сэнсний хурд автоматаар тохируулагдана.

## Арын агааржуулалтын системийн удирдлага

▶ Агааржуулалтын системийн удирдлагын самбар (5 ба 7 зорчигчтой загвар)




A Зүүн талын температур удирдлагын товч

B Автомат горимын товч

C Сэнсний хурдны удирдлагын товч

D Үлээх чиглэл тохируулах товч

E Баруун талын температур удирдлагын товч

F “OFF” товч

▶ Арын олон үйлдэлт самбар (4-н зорчигчтой загвар)




A Зүүн талын температур удирдлагын товч

B Автомат горимын товч

C Сэнсний хурдны удирдлагын товч

D Үлээх чиглэл тохируулах товч

E Баруун талын температур удирдлагын товч

F “OFF” товч

▶ Урд олон үйлдэлт самбар




A Үлээх чиглэл тохируулах товч

B Сэнсний хурдны удирдлагын товч

C “OPTION” товч (→P. 74)

D “REAR” товч

E “FRONT” товч (→P. 71)

F “SYNC” товч

G “A/C” товч

# Хаалганы түгжээ

Түлхүүрийн алсын удирдлага, хаалга түгжих товч, Entry функц ашиглан автомашиныг түгжих, түгжээ тайлах боломжтой.

Түлхүүрийн алсын удирдлага, Entry функцийг P. 26, 27-с харна уу.

## Гадна талаас хаалга түгжих, тайлах

### Хаалга түгжих товч ашиглах




1 Бүх хаалга түгжих

2 Бүх хаалганы түгжээ тайлах

### Дотор талын түгжих товч (түгжих үед)



Дотор талын түгжих товч даран хаалга түгжинэ.

### Хаалганы дотор бариул (түгжээ тайлах)



Урд хаалга:

Тухайн хаалганы түгжээ тайлж хаалга нээх үед бариулнаас татна.

Түгжээ тайлагдах үед түгжих товч дээш гарч ирнэ.

Арын хаалга:

Бариулнаас татах үед түгжээ тайлагдана. Бариулнаас дахин татах үед хаалга нээгдэнэ.

Түгжээ тайлагдах үед түгжих товч дээш гарч ирнэ.

# Автомат цонх

## Цонх нээх ба хаах

Дараах товчоор автомат цонхыг нээх, хаах боломжтой.

Товчийг дарах үед цонх дараах байдлаар ажиллана:




1 Хаах

2 Гүйцэд хаах*

3 Нээх

4 Гүйцэд нээх*

*: Цонхыг дунд нь зогсоохын тулд товчийг эсрэг чиглэлд хөдөлгөнө.

## Санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх (Цонх түгжих товч)




Тус функц нь бага насны хүүхэд санамсаргүйгээр зорчигчийн цонх ажиллуулахаас сэргийлнэ.

Товчийг дарна.

A индикатор асч зорчигчийн цонх түгжигдэнэ.

Жолоочийн хаалган дахь цонхны товчоор зорчигчийн цонхийг нээх буюу хааж болно.

# Дээврийн нээлхий (тоноглогдсон автомашинд)

## Дээврийн нээлхий ажиллуулах

### Нээх ба хаах




1 Дээврийн нээлхий нээх*

Шууд бүрэн нээгдэхгүй ба бүрэн нээгдэхийн өмнөх байрлалд салхины чимээг бууруулж хагас нээгдэнэ.

Товчийг дахин дарж дээврийн нээлхийг бүрэн нээнэ.

2 Дээврийн нээлхий хаах*

*: Дээврийн нээлхийг хагас нээх үед товчны аль нэг талыг дарна.

### Өргөх ба буулгах




1 Дээврийн нээлхий өргөх*

2 Дээврийн нээлхий буулгах*

*: Дээврийн нээлхийг хагас нээх үед товчны аль нэг талыг зөөлөн дарна.

# Шатахууны савны таг

## Шатахуун цэнэглэхийн өмнө

- Бүх хаалга, цонх хааж асаах товчийг OFF горимд унтраана.
- Шатахууны төрлийг нягтлана.

## Шатахууны савны таг онгойлгох



1 Хөшүүргийг татна.



2 Тагийг зөөлөн эргүүлэн нээгээд тусгай сууринд байрлуулна.

## Шатахууны савны таг хаах



Шатахуун цэнэглэж дууссаны дараа тагийг чаг хийж дуугарах хүртэл эргүүлнэ. Тагнаас гараа авах үед таг эсрэг чиглэлд бага зэрэг буцна.

# Тээшний хаалга

## Тээшний хаалга нээх, хаах

### ■Тээшний хаалга дотор талаас нээх, хаах

▶ Зүүн жолооны хүрдтэй



Товчийг удаан дарна.

Тээшний автомат хаалга автоматаар нээгдэх буюу хаагдана.

Тээшний хаалга ажиллуулахын өмнө түгжээ тайлна.

Тээшний автомат хаалга ажиллаж байх үед товчийг дахин дарахад хаалганы ажиллагаа зогсоно.

Хаалганы ажиллагаа зогссон нөхцөлд товчийг дахин дарах үед хаалга эсрэг чигт ажиллаж эхлэнэ.

▶ Баруун жолооны хүрдтэй



## ■Тээшний хаалга гадна талаас нээх, хаах

▶ Түлхүүрийн алсын удирдлага
→ P. 26

▶ Тээшний хаалганы товч ашиглах

● Нээх



Тээшний хаалга түгжигдээгүй үед: Тээшний хаалга нээх товч дарна.

Тээшний хаалга түгжээтэй үед: Биедээ электрон түлхүүртэй үед тээшний хаалга нээх товч дарна.

Тээшний автомат хаалга автоматаар нээгдэнэ.

Тээшний автомат хаалга ажиллаж байх үед товчийг дахин дарахад хаалганы ажиллагаа зогсоно.

● Хаах



Тээшний хаалганы доод хэсэгт байрлах товчийг дарна.

Тээшний автомат хаалга автоматаар хаагдана.

Тээшний хаалганы доод хэсэгт байрлах товчийг дахин дарахад хаалганы ажиллагаа зогсоно.

Товчийг дахин дарах үед хаалга эсрэг чигт ажиллаж эхлэнэ.

● Тээшний хаалга хаагаад хаалганаас холдсоны дараа бүх хаалга түгжих (хаагаад түгжих [хаалганаас холдох] функц)



1 Электрон түлхүүртэй үедээ тээшний хаалганаас бусад бүх хаалга хаагаад тээшний хаалганы доод хэсэгт байрлах товчийг дарна.

2 Дуут дохио дуугарах үед тээшний хаалганаас холдоно.

## ■Kick сенсор (Гарны оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин) ашиглан тээшний хаалга нээх, хаах

Гарны оролцоогүй тээшний автомат хаалга нь арын гуперны төв хэсгийн доогуур хөлөө оруулаад гаргах үед тээшний автомат хаалгыг автоматаар нээх буюу хаах функц юм. Дараах бүх нөхцөл бүрдсэн үед гарны оролцоогүй тээшний автомат хаалга ажиллана:

- Асаах товч OFF, эсвэл P араатай ON горимд байх.
- Kick сенсор идэвхжүүлсэн.
- Биедээ электрон түлхүүртэй.

1 Биедээ электрон түлхүүртэй үед арын гуперны Smart entry & start системийн ажиллах хүрээ болох 30-50 см (11.8-19.7 инч) зайд зогсоно.




A Kick сенсор

B Гарны оролцоогүй тээшний автомат хаалга ажиллах хүрээ

C Smart entry & start системийн ажиллах хүрээ

2 Дуут дохио дуугарсны дараа арын гупернаас 10 см (3.9 инч) зайд хөлөө оруулаад буцаж гаргана.




A Kick сенсор

B Гарны оролцоогүй тээшний автомат хаалга ажиллах хүрээ

3 Kick сенсор гуперны доор хөл ороод гарсныг мэдрэх үед дуут дохио дуугарах ба тээшний хаалга автоматаар нээгдэх буюу хаагдана.

# Анхааруулах гэрэл/индикаторын жагсаалт

**Даруй аюулгүй газар автомашинаа зогсоож Lexus дилертээ хандана уу. Үргэлжлүүлэн жолоодох нь аюултай байж болно.**

| | |
|---|---|
| (Улаан) | Тоормосны системийн анхааруулах гэрэл |

**Даруй аюулгүй газар автомашинаа зогсоож Lexus дилертээ хандана уу.**

| | | | |
|---|---|---|---|
| | Аккумулятор цэнэглэх системийн анхааруулах гэрэл | | Хөдөлгүүрийн тосны даралт багассаныг анхааруулах гэрэл |

**Даруй өөрийн Lexus дилер дээр оношилгоо хийлгэнэ үү.**

| | | | |
|---|---|---|---|
| (Шар) | Тоормосны системийн анхааруулах гэрэл | OFF | Lexus parking assist-sensor OFF индикатор |
| | Доголдол анхааруулах гэрэл | OFF | PKSB OFF индикатор (тоноглогдсон автомашинд) |
| | SRS анхааруулах гэрэл | | Дөрөөний буруу ажиллагааг анхааруулах гэрэл |
| ABS | ABS анхааруулах гэрэл | A OFF (Анивчих) | Stop & Start cancel индикатор (тоноглогдсон автомашинд) |
| (Улаан) | Жолооны механизмын анхааруулах гэрэл | | Шарвалтын индикатор |
| (Шар) | Жолооны механизмын анхааруулах гэрэл | 4LO (Анивчих) | 4 дугуйн хөтлөх системийн нам хурдны горимын индикатор |
| OFF (Асах, анивчих) | PCS анхааруулах гэрэл (тоноглогдсон автомашинд) | (Анивчих) | Төвийн дифференциал цоожлогчийн индикатор |
| OFF | BSM OFF indicator (тоноглогдсон автомашинд) | HOLD (Анивчих) | Тоормос баригчийн ажиллагааны индикатор |
| RCTA OFF | RCTA OFF индикатор (тоноглогдсон автомашинд) | (Анивчаад үргэлжлэн асах) | Дугуйн даралт анхааруулах гэрэл |
| RCD OFF | RCD OFF индикатор | | |

Дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.

## Засах үйлдлийг хийнэ.


(Шаргал)

LTA индикатор (тоноглогдсон автомашинд)



Шатахуун багассаныг анхааруулах гэрэл




AdBlue™-н түвшин багас-саныг анхааруулах гэрэл (тоноглогдсон автомашинд)



Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүсний гэрэл




Арын зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл


(Анивчил-гүйгээр асах)

Дугуйн даралт анхааруулах гэрэл*


(Анивчих)

Зогсоолын тоормосны индикатор

## Зогсоод шалгана.



Хөргөлтийн шингэний хэм анхааруулах гэрэл

Дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.

## “Хэрэглэгчийн гарын авлага” уншина уу.

- Эргэх дохионы индикатор
- Оврын гэрлийн индикатор
- Холын гэрлийн индикатор
- AHS системийн индикатор (тоноглогдсон автомашинд)
- Урд манангийн гэрлийн индикатор
- Хойд манангийн гэрлийн индикатор (тоноглогдсон автомашинд)
- PCS анхааруулах гэрэл (тоноглогдсон автомашинд)
- (Цагаан, ногоон) LTA индикатор (тоноглогдсон автомашинд)
- (Шаргал) LTA индикатор (тоноглогдсон автомашинд)
- Динамик радарын хурд баригчийн индикатор (тоноглогдсон автомашинд)
- Хурд баригчийн индикатор
- Хурд баригчийн “SET” индикатор
- BSM хажуугийн толины индикатор (тоноглогдсон автомашинд)
- BSM OFF индикатор (тоноглогдсон автомашинд)
- RCTA OFF индикатор (тоноглогдсон автомашинд)
- RCD OFF индикатор
- Lexus parking assist-sensor OFF индикатор
- PKSB OFF индикатор (тоноглогдсон автомашинд)
- Эко жолоодлогын индикатор
- Stop & Start индикатор (тоноглогдсон автомашинд)
- Stop & Start cancel индикатор (тоноглогдсон автомашинд)
- Хөдөлгүүр халаагчийн индикатор (дизель)
- (Анивчих) Шарвалтын индикатор
- VSC OFF индикатор
- Уруу замд туслах удирдлагын системийн индикатор
- Эргэлтэд туслах функцийн индикатор
- Crawl Control индикатор
- Crawl Control горимын дэлгэц
- Хялбараар бууж суухад туслах горимын индикатор

Дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.

“Хэрэглэгчийн гарын авлага” уншина уу.

| | | | |
|---|---|---|---|
| 4LO | 4 дугуйн хөтлөх системийн нам хурдны горимын индикатор | | Хэт хүйтэн агаарын хэмийн индикатор |
| | Төвийн дифференциал цоожлогчийн индикатор | SPORT S+ | SPORT S+ горимын индикатор |
| (P) | Зогсоолын тоормосны индикатор | CUSTOM | Custom горимын индикатор |
| HOLD | Brake hold standby индикатор | A | AUTO горимын индикатор |
| ECO | Эко жолоодлогын индикатор | | DIRT горимын индикатор |
| COMFORT | Комфорт горимын индикатор | | SAND горимын индикатор |
| SPORT S | SPORT S горимын индикатор | | MUD горимын индикатор |
| HOLD | Тоормос баригчийн ажиллагааны индикатор | | DEEP SNOW горимын индикатор |
| RSCA OFF | “RSCA OFF” индикатор | | ROCK горимын индикатор |
| | Smart entry & start системийн индикатор | | |

Дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.

*: Температурын өөрчлөлт зэргээс шалтгаалан дугуйн хий өөрөө гарах зэргээс шалтгаалж дугуйн хийн даралт анхааруулах гэрэл асч болно. Энэ тохиолдолд дугуйн хийн даралтыг тохируулсны дараа гэрэл унтарна (тодорхой хэдэн минутын дараа). Дугуйны хийн даралт тохируулсан ч гэрэл унтрахгүй байвал та өөрийн Lexus дилерт хандаж системийг оношлуулна уу.

# Электрон түлхүүр, эсвэл хурууны хээ таних систем (тоноглогдсон автомашинд) хэвийн ажиллахгүй үед

## Хаалга түгжих, тайлах




1 Бүх хаалга түгжинэ

2 Бүх хаалга тайлна

Түлхүүрийг арагш эргүүлэх үед жолоочийн хаалга тайлагдана. 5 секундын дотор дахин эргүүлэхэд бусад хаалга тайлагдана.

## Хөдөлгүүр асаах

1 Арааг P байрлалд байгааг шалгаад тоормосны дөрөө гишгэнэ.



2 Асаах товчинд электрон түлхүүр, түлхүүр картыг (тоноглогдсон автомашинд) зурагт үзүүлсний дагуу хүргэнэ.

Электрон түлхүүр танигдах үед анхааруулах дохио дуугарах ба асаах товч ON горимд шилжинэ.

Хэрэглэгчийн хүсэлтээр хийх тохиргоогоор Smart entry & start систем салгагдсан үед асаах товч ACC горимд шилжинэ.

3 Тоормосны дөрөөг сайтар гишгэх ба мэдээллийн дэлгэц дээр  гарч байгааг нягтлана.

4 Асаах товчийг богино, чанга дарна.

Хурууны хээ таних системтэй автомашин: Хурууны хээ таних системд доголдол үүссэн үед нэмэлт тохиргооны функц ашиглан хурууны хээ таних системийг унтраана. Электрон түлхүүрийг биедээ авч явах үед тус байдлаас мөн асаах боломжтой.

Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч хөдөлгүүр асахгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Түлхүүрийн зайг шинээр солино. Зай солих тухай дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу. Таньд нэмэлт мэдээлэл, тусламж хэрэгтэй үед өөрийн Lexus дилерт хандана уу.

## Хөдөлгүүр асахгүй үед

Үйлдлийг зөв дарааллын дагуу хийж гүйцэтгэнэ.

Тоормосны дөрөө

Хөдөлгүүр асаах оролдлого хийх үед тоормосны дөрөөг сайтар гишгэнэ. (→P. 29)

Зөв дарааллаар үйлдлийг хийсэн ч хөдөлгүүр асахгүй үед “Хэрэглэгчийн гарын авлага”-с дэлгэрэнгүй мэдээлэл харах, эсвэл өөрийн Lexus дилертээ хандана уу.

# Тэмдэглэл

Тэмдэглэл

©2021 ТОЁОТА МОТОР КОРПОРАЦ
Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Тус материалыг Тоёота Мотор Корпорацийн бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлах, ашиглахыг хориглоно.